

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 2 дугаар сарын дугаар

### Тэргүүн Мэдээ

#### Автомашинны хаягдал батерейг зохистой боловсруулах, дахин ашиглах судалгаа хийв.



Монгол Улсад автомашинны батерейтэй холбоотой эрх зүйн орчин бүрдээгүйгээс үүдэн хаягдал хар тугалган батерей нь байгаль орчинд ноцтой асуудал үүсгэх нэг шалтгаан болж байна. Мөн үнэт металл агуулсан хайбрид автомашинны батерейнд орсон металлыг ялгаж, дахин ашиглах талаар цаашид судлах шаардлагатай байгаа билээ.

Иймд ЖАЙКА-гаас Монгол Улсад автомашинны хаягдал батерейг боловсруулан дахин ашиглах талаар судалгаа хийж ирсэн Тохокугийн Их сургуулийн Yu Jeongsoo профессорын оролцоотойгоор “Монголд автомашинны хаягдал батерейг зохистой боловсруулах, дахин ашиглах судалгаа” –г хэрэгжүүлж, 2 сарын 12-ны өдөр уг судалгааны үр дүнг танилцуулах хурлыг зохион байгуулав. Зам тээврийн хөгжлийн яамны харьяа байгуулагуудын 50 гаруй ажилтан оролцсон энэхүү хуралд судалгааны явцад тодорхой болсон хаягдал батерейтэй холбоотой эрх зүйн орчинг бий болгох, олон нийтийн ойлголтыг сайжруулах шаардлагад үндэслэн цаашид авах арга хэмжээний талаар идэвхитэй санал солилцов.

### Төслийн хэрэгжилт

#### Монголын Татварын Ерөнхий Газрын байцаагч нар Япон улсад сургалтад хамрагдаж, үнэ шилжилтийн татварын тогтолцоотой танилцав.



1 сарын 29-ний өдрөөс 2 дугаар сарын 4-ний өдрүүдэд Монголын ТЕГ-ын 14 ажилтан (ТХА) “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төслийн 2-р шат”-ны үйл ажиллагааны хүрээнд, Японд зохион байгуулсан сургалтад оролцов. Сургалтын явцад Татварын их сургуулийн дэмжлэгээр японы үнэ шилжилтийн татварын тогтолцооны талаар суралцахын зэргэцээ, Монгол дахь олон улсын татвар ногдуулалтай холбоотой бодит жишээн дээр ажиллаж, туршлага судалсан нь чухал ач холбогдолтой болов. Мөн УИХ-д өргөн бариад байгаа Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад тус төслөөр дамжуулан Японы татварын тогтолцооны мэдлэг туршлагыг хуваалцан, зөвлөгөө өгөх зэргээр хамтран ажилласныг Монголын талын холбогдох албан тушаалтнууд өндрөөр үнэлж байгаа юм.

#### Улаанбаатарын Олон улсын шинэ нисэх буудлын нисэхийн хөдөлгөөний үйлчилгээний албаны бэлтгэл ажил явагдаж байна.



(ТХА) “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн (иений хөнгөлөлттэй зээлээр баригдаж буй) хүрээнд нисэх буудлын ашиглалтын үеийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны чадавхийг бэхжүүлэх ажилд шамдан ороод байна. 1 дүгээр сарын 28-аас 2 дугаар сарын 1-ний өдрүүдэд энэхүү төслийн хүрээнд дэмжлэг үзүүлж ирсэн шинээр нэвтрүүлэх үзүүлэлтэд тулгуурласан навигацийн (PBN) нислэгийн шалгалтын үр дүнг ЖАЙКА-ийн мэргэжилтэн баталгаажуулав. Мөн 2 сарын 18-аас БНСУ-ын Инчоны нисэх буудалд дадлагажуур (симулятор) ашиглан нислэгийн хөдөлгөөний удирдагч нарт зориулсан сургалтыг ЖАЙКА-ийн мэргэжилтний дэмжлэгтэйгээр зохион байгуулж эхлэсэн зэргээр шинэ нисэх буудлын ашиглалтыг эхлүүлэхэд чиглэсэн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны бэлтгэл ажил идэвхтэй явагдаж байна.

## “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулах, хөрс сайжруулах технологи нэвтрүүлэх замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх төсөл”-ийн тайлангийн хурал болов.



2 дугаар сарын 15-ны өдөр Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвд “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулах, хөрс сайжруулах технологи нэвтрүүлэх замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх төсөл”-ийн (Япон талын хэрэгжүүлэгч : Хоккайдо мужийн ЖДҮ эрхлэгчдийн холбооны Токачи салбар) эцсийн тайлангийн хурал зохион байгуулагдлаа. 2017 онд газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Борнуур суманд орон нутгийн иргэд өөрсдөө ажиллуулах шууд борлуулалтын цэгийг (2019 оны 1 дүгээр сараас өвлийн улиралд ажиллаж эхэлсэн) нээсэн билээ. Тус төсөл нь 2 дугаар сарын сүүлээр дуусах ба цаашдаа орон нутгийн иргэд харилцан ярилцсаны үндсэн дээр үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлж, бие даан үйл ажиллагаа явуулах юм.

## Японд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн манлайллыг хөгжүүлэх” сургалт зохион байгуулав.




1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2 дугаар сарын 2-нд ТХА “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд Японд сургалт зохион байгуулав. Энэхүү сургалтын хүрээнд төрийн байгууллагын 5 ажилтан болон хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтын (DET) сургагч багш болох хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн Окинава мужид зочилж, орчны хүртээмжтэй байдал, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх зэрэг Япон улсын үйл ажиллагаатай танилцав.

Цаашид Японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн засаг захиргаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, холбогдох байгууллагуудын үүрэг хариуцлага, хамтран ажиллах арга хэлбэрээс санаа авч төрийн захиргааны ажилтан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцооны загварыг бий болгохоор хамтран ажиллах юм.

## Сайн дурын үйл ажиллагаа

### Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (Сувилагчаар ажиллаж буй сайн дурын гишүүн)



Хавдар Судлалын Үндэсний Төвд томилогдон ажиллаж буй Күнимаса Асами сайн дурын гишүүн тогтмол хугацаанд семинар зохион байгуулж, сувилгааны түүх хөтөлж хэвших, хагалгааны өмнө ба дараах сувилгааны чанарыг сайжруулах, чагнах тэмтрэх зэрэг ажиглалтын аргуудыг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Семинарын дараа зааж өгсөн мэдлэг, арга зүйг сувилгаанд бодитоор хэрхэн ашиглаж байгааг шалгахад тасгуудаар явж, шаардлагатай бол газар дээр нь дахин зааварчлага өгч иржээ. Ингэж ажилласан нь мэдэгдэхүйц үр дүнгээ өгч сувилагчдын сувилгааны мэдлэг, арга зүйг сайжруулахад хувь нэмэр оруулсан хэмээн тус эмнэлэгийнхэн түүний ажлыг өндрөөр үнэлж байна.



## ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

### Ерөнхий боловсролын сургуулийн залуу багш нарт зориулсан боловсролын нэгдсэн семинар зохион байгууллаа.



1 дүгээр сарын 10-ны өдөр 2017 онд “Хөтөлбөрийн менежментийг сайжруулах нь” сэдэвт сургалтанд хамрагдсан Ц.Нарантуяа (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйч) боловсролын нэгдсэн семинар зохион байгууллаа. Байгалийн ухааны залуу багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан дээрх семинарт Улаанбаатар хотын 6 дүүргийн бага боловсролын 54 залуу багш нараас гадна (ТХА) “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн (PROCESS) мэргэжилтэн Фүкүо оролцлоо. Сургалтанд оролцогчид гарын доорх материалаар хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, багшлах арга зүй, самбар төлөвлөлт зэрэг олон зүйлийг сурсан тухайгаа ярьж байлаа. [Сургалт](#)

[төгсөгчдийн холбооны НР](#)



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага(ЖАЙКА).

Монгол дахь Төлөөлөгчийн Газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: [mg\\_oso\\_rep@jica.go.jp](mailto:mg_oso_rep@jica.go.jp)